



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/134

Номгон

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан 7
залуусын эрүүл мэндийн даатгалын
хамрагдалтыг нэмэгдүүлэх тухай

Баянхонгор аймаг нь улсын хэмжээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч буй Эрүүл мэндийн байгууллагын тоогоороо тэргүүлж байна. Тусламж үйлчилгээ авч байгаа иргэдийн 60-80 гаруй хувь нь эрүүл мэндийн даатгалаа төрөөс хариуцан төлүүлдэг өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Эрүүл мэндийн даатгалын хамралт 2018 онд 66 хувьтай байсан бол 2020 онд 47 хувь болтлоо буурсан.

Гэвч хөдөлмөрийн идэвхтэй 20-40 насны хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, малчид, оюутан залуус маань эрүүл мэндийн даатгалаа тухай бүр төлдөггүй зөвхөн өвчилсөн үедээ эрүүл мэндийн байгууллагуудад хандаж байгаа тул эрт үеийн урьдчилан сэргийлэхийн багц үзлэг, рашаан сувилал болон эмийн үнийн хөнгөлөлт, хорт хавдрын эрт илрүүлэг, В, С, Д вирусийн илрүүлэг, баталгаажуулах шинжилгээ, хувийн эмнэлгүүдээр тэр бүр хангалттай үйлчлүүлж чадахгүй байгааг тэмдэглэн:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2, 7.2.1, 8.1.2, 8.3.2, 8.3.3, 19.3, 25.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн идэвхтэй 20-40 насны хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, малчид, оюутан залуусыг эрүүл мэндийн даатгалд идэвхтэй хамруулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.


2.Эрүүл мэндийн даатгалд хамрагдсаны ач холбогдол, үр нөлөөний талаар иргэдэд мэдээлэл сургалт, сурталчилгаа хүргэж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс (А.Цэрмаа), Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал) Хүнс хөдөө аж ахуйн газар (Ж.Баттөр) нарт тус тус хариуцуулсугай.

3.Малчдын ноосны урамшуулал, сүүний урамшуулал, арьс ширний урамшуулал олгохдоо Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төлүүлэх, бүртгэлгүй малчин иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан залуусыг эрүүл мэндийн даатгалд заавал хамруулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар,


601210001

мэндийн даатгалд заавал хамруулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, Нийгмийн даатгалын хэлтэс (Д.Мөнхбат), Политехникийн коллеж (Д.Бат-Орших) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Уг захирамжийн хүрээнд нэр заагдсан байгууллагуудын удирдлагуудад чиглэл өгч, үр дүнг тооцож, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 06-ны
өдрийн А/434 дүгээр захирамжийн хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ
БОЛОН АЙМАГ ДАХЬ ТӨЛӨХ ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Он	Хувь хэмжээ	Тайлбар
2016	46080 төгрөг	Заавал төлнө
2017	57600 төгрөг	Заавал төлнө
2018	28800 төгрөг	Заавал төлнө
2019	38400 төгрөг	Заавал төлнө
2020	50400 төгрөг	Заавал төлнө
2021	50400 төгрөг	Заавал төлнө
Нийт	271680 төгрөг	
Хас банк	5000148565	Аймаг дахь данс
Хаан банк	5246025587	
Төрийн банк	232100365509	

Холбогдох хуулийн заалт: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 болон 25 дугаар зүйлийн 25.2-т заасны дагуу 2016 оноос хойшхи шимтгэлийг тухайн үед мөрдөж байсан хэмжээгээр заавал нөхөн төлүүлнэ.

-----oOo-----